



ИНД - 172

Иргэний Нисэхийн Дүрэм

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-172 нь Монгол улсын Нислэгийн мэдээллийн бүсэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллгааны шаардлагыг тогтооно. Мөн энэ Дүрэм нь гэрчилгээжсэн байгууллагын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны болон техникийн стандартын тогтооно.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ нь дараах үйлчилгээнээс бүрдэнэ:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээ;
- (2) бүсийн удирдлагын үйлчилгээ;
- (3) ойртолтын удирдлагын үйлчилгээ;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) анхааруулах үйлчилгээ;
- (7) Даргын шаардлагатай гэж үзсэн, эсхүл аюулгүй, үр дүнтэй иргэний нисэхийн системд шаардлагатай аливаа бусад нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-172-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-172, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо
Анхны боловсруулалт	2002 оны 12 сарын 20
Нэмэлт, өөрчлөлт 1	2003 оны 06 сарын 05
Нэмэлт, өөрчлөлт 2	2010 оны 03 сарын 22
Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)	2019 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-172-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 172-ын 2018 оны 07 сарын 20-ны А.13-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
172.1. Зорилго.....	1
172.3. Нэр томъёо ба товчлол.....	1
172.5. Гэрчилгээний шаардлага	1
172.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт	2
172.9. Гэрчилгээ олгох	2
172.11. Гэрчилгээний эрх.....	2
172.13. Гэрчилгээний хугацаа.....	3
172.15. Гэрчилгээ сунгах.....	3
172.17. Нөөц	3
В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	4
172.51. Ажилтанд тавих шаардлага	4
172.53. НХҮ-ний сургалт	5
172.55. [Нөөц]	5
172.57. Байгууламжийн шаардлага.....	5
172.59. Үйлчилгээ тогтоох болон шилжүүлэх	8
172.61. Ээлжийн удирдлага	8
172.63. Баримтжуулалт	8
172.65. Нөөц төлөвлөгөө	9
172.67. Зохицуулалтын шаардлага	9
172.69. Байгууламжийн статусыг мэдээлэх.....	10
172.71. Нислэгийн ерөнхий мэдээлэлд тавих шаардлага	11
172.73. Цаг уурын мэдээлэл болон мэдээлэх	11
172.75. Бүсийн болон ойртолтын удирдлагын үйлчилгээ.....	12
172.77. Аэродромын удирдлагын үйлчилгээ	13
172.79. Тусгай зориулалтын агаарын зай.....	15
172.81. Удирдлагын хариуцлага.....	15
172.83. Хөдөлгөөний эрэмбэ	16
172.85. Нислэгийн хөдөлгөөний урсгал зохицуулалт.....	17
172.87. НХҮ-ын зөвшөөрөл.....	17
172.89. Аяллын нислэгийн түвшин	18
172.91. НХҮ-ын зөвшөөрлөөс хазайх.....	18
172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ.....	19
172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ	20
172.97. Анхааруулах үйлчилгээ.....	21
172.99. Нислэгийн төлөвлөгөө.....	23
172.101. Цаг.....	24
172.103. Өндөр хэмжигчийг тохируулах журам.....	24
172.105. Радио холбооны журам	25
172.107. НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээ	26
172.109. Агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон тогтмол бус үйл ажиллагаа	26
172.111. Ноцтой зөрчил, эсхүл ослын дараах арга хэмжээ	26
172.113. Зөрчил.....	27
172.115. Бүртгэл хөтлөх.....	27
172.117. Бүртгэлийн дэвтэр болон ажлын байрны бүртгэл	29
172.119. Аюулгүйн хамгаалалт	30
172.121. Үйлчилгээний саатал	30
172.123. Аюулгүй байдлын удирдлага.....	31
172.125. НХҮ-ний байгууллагын Ерөнхий заавар	32
С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага	35

172.151.	Байнгын хэрэгжилт	35
172.151A.	Шилжилтийн зохицуулалт	35
172.153.	Үйл ажиллагааны журам	35
172.155.	Туршилтын зөвшөөрөл	35
172.157.	НХУ-ын зөвшөөрөл олгохоос татгалзах	36
172.159.	VFR-ийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх	36
172.161.	Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	36
172.163.	Үйлчилгээг цуцлах болон шилжүүлэх	37
172.165.	Аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр	37
D	Бүлэг - Бусад НХУ	38
172.201.	Ерөнхий зүйл	38
172.203.	Шаардлага	38
172.205.	Хүсэлт гаргах	38
172.207.	Гэрчилгээ олгох	38
172.209.	Үйл ажиллагааны нөхцөл	38
E	Бүлэг - Зайчлалын шалгуур болон минима	39
172.251.	Босоо зайчлал	39
172.253.	Хосолмол ил харааны зайчлал	39
172.255.	Аэродромын бүсээс гаднах ил харааны зайчлал	39
172.259.	Хугацаат тууш зайчлал	40
172.259.	Зайт тууш зайчлал	40
172.261.	Хэвтээ зайчлал	40
172.263.	Хэрэглэлээр ойртолт үйлдэж байгаа агаарын хөлгүүдийн хоорондох зайчлал	41
172.265.	НХУ-ний бодит ажиглалтын үйлчилгээгээр хангах үеийн багасгасан зайчлал	41
172.267.	НХУ-ний бодит ажиглалтын үйлчилгээгээр тогтоогдоогүй хяналттай нислэгээс зай барих	41
172.269.	Separation from holding aircraft in the НХУ-ний бодит ажиглалтын үйлчилгээ	42
172.271.	Жагсаалын нислэг	42
172.273.	ХБЗ-ны багасгасан зайчлал - ерөнхий зүйл	42
172.275.	ХБЗ-ны багасгасан зайчлал - departure versus departure	42
172.277.	ХБЗ-ны багасгасан зайчлал - arrival versus departure	42
172.279.	ХБЗ-ны багасгасан зайчлал - arrival versus arrival	43
172.281.	Зэрэгцээ ХБЗ-ны үйл ажиллагаа	43
172.283.	Separation from an aircraft dumping fuel	43
172.285.	Цэргийн агаарын хөлгийн зайчлал	44
172.287.	IFR-аар нислэгт гаргах зайчлал	44
172.289.	Helicopters and unpowered aircraft	44
172.291.	Дагалдах хуйлралын зайчлал	44
172.293.	Идэвхтэй байгаа тусгай зориулалтын агаарын зайнаас зайчлал хадгалах	45
172.295.	[Хүчингүй]	45
F	Бүлэг - Стандарт хэвшмэл хэллэг	46
172.351.	Хамрах хүрээ	46
172.353.	Нислэгийн хөдөлгөөний удирдагч/Нисгэгчийн хэвшмэл хэллэг	46
172.355.	НХУ-ний зохицуулалтын стандарт хэллэг	48
G	Бүлэг - НХУ-ний бодит ажиглалтын журам	49
172.401.	Транспондерийн түвшний мэдээллийг баталгах	49
172.403.	Хурдны хяналт	49

Н Бүлэг - Шилжилтийн зохицуулалт.....	50
172.451. НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт	50
172.453. НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт	51

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий зүйл

172.1. Зорилго

(a) Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) Монгол Улсын FIR-д НХҮ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- (2) тухайн байгууллагын НХҮ үзүүлэхэд тавих үйл ажиллагааны болон техникийн стандарт.

(b) А, В болон С Бүлэг нь НХҮ-ний тодорхойлолтын энэ хэсгийн (1)-(6)-д заасан НХҮ-нд хамаарна.

(c) D Бүлэг болон энэ зүйл нь НХҮ-ний тодорхойлолтын энэ хэсгийн (7)-д заасан үйлчилгээнд хамаарна.

172.3. Нэр томъёо ба товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.

172.5. Гэрчилгээний шаардлага

Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын (цаашид “НХҮБ” гэж) гэрчилгээний эрхийн хүрээ болон хязгаарлалтад зааснаас бусад тохиолдолд НХҮ үзүүлэхгүй.

172.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) дараах мэдээллийг шаардсан САА 24172/01 маягтыг бөглөнө:
 - (i) хүсэлт гаргагчийн нэр, Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг;
 - (ii) тусгай НХҮ, эсхүл үзүүлэх НХҮ;
 - (iii) үйлчилгээ үзүүлэх аэродромын байрлал, эсхүл агаарын зайн тодорхойлолт;
 - (iv) маягтад тусгахыг Даргаас шаардаж болох, хүсэлт гаргагч болон зорьж байгаа үйлчилгээтэй холбоотой бусад мэдээлэл.
- (2) гүйцэд бөглөсөн маягтыг дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлнэ:
 - (i) 172.125-д заасан Ерөнхий заавар;
 - (ii) зохих хүсэлтийн хураамжийн төлбөр.

172.9. Гэрчилгээ олгох

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл хүсэлт гаргагч нь НХҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч нь В Бүлэгт заасан шаардлагыг хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч болон 172.51-д шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь зөв, тохирох хүн байх;
- (3) тухайн гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс аливаа цаг хугацаанд, ижил НХҮ-нд зөвхөн нэг гэрчилгээ хүчинтэй байгаа болохыг бататгана.

172.11. Гэрчилгээний эрх

(a) НХҮБ-ын гэрчилгээ нь дараах НХҮ болон тухайн үйлчилгээний сургалт, үнэлгээнээс гэрчилгээ эзэмшигч аль үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй болохыг заана:

- (1) бүсийн удирдлагын үйлчилгээ;
- (2) ойртолтын удирдлагын үйлчилгээ;
- (3) аэродромын удирдлагын үйлчилгээ;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) анхааруулах үйлчилгээ;
- (7) D Бүлгийн дагуу хангах аливаа бусад үйлчилгээ.

(b) НХҮБ-ын гэрчилгээ нь:

- (1) тухайн үйлчилгээгээр хангагдах аэродром, эсхүл агаарын зайг тогтооно;
- (2) Даргын хамааралтай гэж үзсэн нөхцөлийг багтааж болно.

172.13. Гэрчилгээний хугацаа

- (a) НХҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) НХҮБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.
- (c) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.
- (d) Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн бол НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.

172.15. Гэрчилгээ сунгах

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24172/01 маягтын дагуу гаргана.
- (b) Тухайн хүсэлтийг гэрчилгээнд заасан хугацаанд, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

172.17. Нөөц

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

172.51. Ажилтанд тавих шаардлага

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааварт заасан НХҮ бүр нь дараах шаардлага хангасан болохыг хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй, Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан:
 - (i) санхүүжүүлэгдэж чаддаг байх;
 - (ii) энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэгддэг байх;
- (2) дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:
 - (i) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах;
 - (ii) 172.123-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НХҮ болон аливаа холбогдох сургалт, эсхүл үнэлгээ хийх ажиллагааг удирдах, дэмжих болон хангах хангалттай тооны ажилтан.

(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын тогтолцооны удирдлагатай холбоотой ур чадвар, туршлагаа харуулсан байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НХҮ болон тухайн үйлчилгээний сургалт болон үнэлгээг хийх эрхийг хүсэлт гаргагчаас олгосон ажилтны ур чадварыг бататгах;
- (2) дээрх ажилтанд, түүний зөвшөөрлийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох;
- (3) эрх бүхий ажилтан нь энэ Хууль болон ИНД-65-ын дагуу олгосон зохих хүчинтэй үнэмлэх болон зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах;
- (4) боломжтой бол эрх бүхий ажилтан нь бүх холбогдох болон хүчинтэй мэдээлэлтэй танилцсан бол, зөвхөн тухайн зэрэглэл, эсхүл зэрэглэлүүдийн эрхийг хэрэгжүүлдэг болохыг бататгах;
- (5) зэрэглэлтэй НХҮ-ний үнэмлэх эзэмшигчийн хувьд, ИНД-65-ын туршлага хадгалах шаардлагын хэрэгжилтийг хялбаршуулах;
- (6) боломжтой бол нислэгийн хөдөлгөөний удирдагч нь дараах тохиолдолд тухайн зэрэглэл, эсхүл зэрэглэлүүдийн эрхийг хэрэгжүүлэхгүй болохыг бататгах:
 - (i) ЭМГ-ний аливаа нөхцөлийг хангаснаас бусад тохиолдолд;
 - (ii) эрүүл мэндийн таагүй байдал нь эрхээ аюулгүй хэрэгжүүлэх чадамжгүй болгох.

172.53. НХҮ-ний сургалт

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг сургах болон үнэлэх журам болон хөтөлбөрийг боловсруулна:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагч;
- (2) нислэгийн мэдээллийн ажилтан;
- (3) HF үелзлэлийн нисэхийн холбооны үйлчилгээ үзүүлэхэд шууд оролцдог ажилтан;
- (4) дараах ажилтныг дэмжих ажиллагаанд шууд оролцдог ажилтан:
 - (i) зэрэглэл бүхий нислэгийн хөдөлгөөний удирдагч;
 - (ii) зэрэглэл бүхий нислэгийн мэдээллийн ажилтан.

(b) Хүсэлт гаргагч, үйл ажиллагааны орчинд зааварчилгаа өгч байгаа ажилтан нь ИНД-65-ийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах журмыг тогтооно.

(c) Хүсэлт гаргагч, үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл хүлээн зөвшөөрөх зорилгоор үнэлгээ хийж байгаа ажилтан нь ИНД-65-ын дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний багшийн, эсхүл шалгагчийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах журмыг тогтооно.

172.55. [Нөөц]**172.57. Байгууламжийн шаардлага**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өөрийн Ерөнхий зааварт заасан НХҮ-д тохирох дараах байгууламжтай байх үүрэгтэй:

- (1) аэродромын удирдлагын цамхаг;
- (2) ойртолтын удирдлагын байр;
- (3) бүсийн удирдлагын төв;
- (4) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр;
- (5) нислэгийн мэдээллийн үйлчилгээний төв;
- (6) сургалт болон үнэлгээ хийх зориулалтын байгууламж.

(b) Энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргагч нь түр цамхаг, эсхүл байртай өөрийн Ерөнхий зааварт заасан аэродромын удирдлагын цамхаг, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) барилга болон байршлын хувьд:
 - (i) аэродромын нислэгийн хөдөлгөөн максимум боломжит алсын барааны харагдацтай байх;
 - (ii) гэрлийн гялбалт, нөлөөллөөс хамгаалагдсан байх;
 - (iii) дуу чимээнээс тусгаарлагчтай байх.
- (2) энэ зүйлийн (b)(1)-ийн шаардлагад нөлөөлөх аливаа бүтээн байгуулалтаас хамгаалсан байх;
- (3) зөвхөн нэг ажилтан байнгын хяналт тавих ажлын байрны хувьд:

- (i) НХҮ-г аль болох бага тасалдуулах, эсхүл бууруулах зорилгоор ариун цэврийн өрөөтэй байх;
 - (ii) өрөөнөөс нүдэнд ил харагдахаар хоол хүнс болон ундааг хадгалах болон бэлтгэх өрөөтэй байх;
- (4) дараах төхөөрөмж болон хүнтэй хоёр талын дуут холбоо тогтоох төхөөрөмжөөр хангасан байх:
- (i) хүсэлт гаргагчийн хариуцсан агаарын зайд, эсхүл түүний зэргэлдээ байгаа агаарын хөлөг;
 - (ii) маневрлах талбай эсхүл түүнтэй зэргэлдээ байгаа агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл болон хүн;
- (5) дараах минимум төхөөрөмжөөр хангасан байх:
- (i) одоогийн болон хүлээгдэж буй аэродромын хөдөлгөөний төлөв байдлыг бие даасан агаарын хөлгийн нэмэлт мэдээлэлтэй хамт харуулах дэлгэцийн систем, эсхүл системүүд;
 - (ii) цахилгаан хангамж;
 - (iii) холбогдох болон хүчинтэй газрын зураг болон нислэгийн зураг;
 - (iv) дуран;
 - (v) цаг;
 - (vi) бүртгэл хадгалах систем;
 - (vii) гаднах агаарын хэм заах хэрэглэл;
 - (viii) QNH дэлгэц;
 - (ix) улаан, ногоон болон цагаан өнгийн дохионы гэрэл;
 - (x) утсан холбоо;
 - (xi) ойртолтын болон буултын туслах хэрэгсэл болон ХБЗ-ны ашиглалтад нөлөөлөх зам, эсхүл төмөр замын дохионы төхөөрөмжийн статусыг хянагч;
 - (xii) алсын барааны харагдац болон үүлний доод суурийн өндрийн хяналтын цэг;
 - (xiii) яриа, эсхүл хэрэв хамааралтай бол, өгөгдөл бичигч төхөөрөмж;
 - (xiv) салхины чиглэл болон салхины хурдны дэлгэц;
 - (xv) ослын дуут анхааруулах систем;
 - (xvi) AFTN терминал, эсхүл хэрэв НХҮ-ний гэрээнд заасан бол, AFTN-аар ихэвчлэн мэдээлэл хүлээн авах болон дамжуулах өөр арга;
 - (xvii) хэрэв хамааралтай бол, аэродромын гэрэлтүүлгийн хяналтын дэлгэц.
- (6) ил хараагаар хяналт тавих байр нь аэродромын түвшинг тодорхойлох зорилгоор анеройд бүхий даралт хэмжүүр, эсхүл барометрийн өндрийн хэрэглэлийн аль нэг нь байх, бие биенээсээ хамааралгүй өндрийн даралтын тохируулгын хоёр хэрэгсэлтэй байна.
- (c) Хүсэлт гаргагч бүсийн удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төв болон ойртолтын удирдлагын байр нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй:
- (1) дараах боломжийг олгодог төхөөрөмжөөр хангасан байх:
 - (i) өргөн боломжтой хоёр талын дуут холбоо барих;
 - (ii) хэрэв хамааралтай бол, хүсэлт гаргагчийн хариуцсан агаарын зайд, эсхүл түүний зэргэлдээ байгаа агаарын хөлөгтэй тоон өгөгдлөөр холбоо барих.
 - (2) дараах минимум төхөөрөмжөөр хангасан байх:

- (i) бодит болон хүлээгдэж байгаа нислэгийн төлөв байдлыг тухайн агаарын хөлөг бүрийн нэмэлт мэдээлэлтэй хамт харуулах дэлгэцийн систем, эсхүл системүүд;
- (ii) цахилгаан хангамж;
- (iii) холбогдох, хүчинтэй газрын зураг болон нислэгийн зураг;
- (iv) цаг;
- (v) бүртгэл хадгалах систем;
- (vi) навигацийн, ойртолтын болон буултын туслах хэрэгслийн ажиллагааг хянах;
- (vii) утсан холбоо;
- (viii) яриа бичигч төхөөрөмж болон хэрэв хамааралтай бол, өгөгдөл бичигч төхөөрөмж;
- (ix) AFTN терминал;
- (x) ойртолтын удирдлагын ажлын байрны хувьд, тухайн аэродромын ойртолтын удирдлагын процедурын, эсхүл ойртолтын удирдлагын бодит ажиглалтын ажлын байранд ILS/MLS-ын ажиллагааг хянах;
- (xi) төгсгөлийн ойртолт, эсхүл агаарын хөлгийн буулт, эсхүл хөөрөлт хариуцсан ойртолтын удирдлагын ажлын байрны хувьд, аэродромын удирдлагын цамхагт ашиглаж байгаа төхөөрөмжтэй ижил эх үүсвэртэй салхины чиглэл болон салхины хурд заах хэрэгсэл.

(d) Хүсэлт гаргагч энэ зүйлийн (b) болон (c)-т шаардсан нисэхийн холбоо навигацийн төхөөрөмж нь ИНД-171-д заасны дагуу ажилладаг болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй.

(e) Хүсэлт гаргагч, НХҮ-нд ашиглах аливаа ил хараагаар ажиглах дэлгэц нь холбогдох мэдээллийн ач холбогдолд анхаарч, хэрэглэхэд хялбар байхуйцаар суурилуулсан байх журмыг тогтоосон байна.

(f) Энэ зүйлийн (b)(4), (5); (c)(1)-д заасан төхөөрөмжийн гэнэтийн саатал, татгалзал, ашиглалт ба хүчин чадлын түвшний бууралт, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгах зорилгоор нөөц төхөөрөмжтэй байна.

(g) Хүсэлт гаргагч энэ зүйлийн (b)(5)(xi), (c)(2)(vi) болон (x)-д шаардсан статус хянагчийг дараах төхөөрөмжид суурилуулсан болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) an aural signal to indicate a change of status; and
- (2) a visual indication of the current status.

(h) Хэрэв хийх боломжгүй бөгөөд бусад шаардлагатай арга хэмжээг авсан бол, түр аэродромын удирдлагын цамхаг болон түр аэродромын нислэгийн мэдээллийн байрыг энэ зүйлийн (b)(5)(xi), (xvi) болон (xvii)-д шаардсан төхөөрөмжөөр хангасан байхыг дараах тохиолдолд шаардахгүй:

- (1) этгээд нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг (b)(5)(xi) болон (xvi)-д шаардсан төхөөрөмжөөс авсан мэдээллээр түр цамхаг, эсхүл түр байрнаас үзүүлэх;
- (2) хэрэв хамааралтай бол, талбайн гэрэлтүүлгийг удирдах.

172.59. Үйлчилгээ тогтоох болон шилжүүлэх

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хүсэлтдээ дараах зүйлсийг хавсаргана:

- (1) гэрчилгээ олгосноос хойш эхний 12 сарын
- (2) *in respect of an aerodrome, or airspace, not currently provided with an air traffic service, a summary of safety factors considered before seeking certification.*

(b) *Each applicant for the grant of an air traffic service certificate intending to assume responsibility for providing any air traffic service from an existing certificate holder, shall include with its application, full details of transitional arrangements endorsed by the chief executives of both organisations.*

172.61. Ээлжийн удирдлага

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) дараах хугацаанд ээлж бүрийн өмнө болон дараа ээлжийн өмнө, ээлж солилцох үйл ажиллагаанд тохиромжтой хугацааг зарцуулах:
 - (i) НХҮ үзүүлж эхлэхээс өмнө;
 - (ii) НХҮ үзүүлж дуусаад.
- (2) НХҮ-ний ажлын байранд ээлж шилжүүлэхээс өмнө нислэгийн хөдөлгөөний явцтай танилцахад 5 минутаас багагүй хугацааг зарцуулдаг байх.

172.63. Баримтжуулалт

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа тусгасан үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай журам, заавар, техникийн ашиглалтын заавар болон удирдлагын бусад баримт бичгийн хувийг бүрдүүлж хадгална.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д заасан баримт бичгийг хадгалах, ашиглах журмыг дараах шаардлагыг хангахуйцаар тогтоосон байна:

- (1) баримт бичгийг түгээхээс өмнө эрх бүхий ажилтан танилцаж зөвшөөрсөн байх;
- (2) *бүх бичиг баримтыг хэвлэн гаргахаас өмнө шалгаж, хянадаг байх;*
- (3) *НХҮ-ний хүчинтэй баримт бичгийг түүнийг мөрдөж ажиллах ажлын байр, ажилтанд хүргэж танилцуулсан байх;*
- (4) хүчингүй болсон баримт бичгийг ажлын байрнаас тухай бүрт нь татан авсан байх;
- (5) архивт шилжүүлж байгаа баримт бичигт хүчингүй болгосон тухай тэмдэглэлийг хийж хадгалах;
- (6) баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг эрх бүхий ажилтан хянаж, зөвшөөрдөг, бүртгэдэг байх;
- (7) өөрчлөлт оруулсан баримт бичгийн хүчинтэй хувийг хүчингүй болгосон хувиас ялгах зорилгоор түүнд тусгайлан тэмдэглэл үйлдсэн байх.

(c) Ажлын байранд тогтмол хадгалахаас бусад баримт бичиг, мэдээллийг цахим хуудсаар дамжуулан түгээж болох ба энэ тохиолдолд цахим хуудаст нэвтрэх эрх, зэрэглэлийг тогтооно.

(d) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a), (b)-д заасан үйл ажиллагааг хариуцах, хяналт тавих этгээдийг томилж, энэ талаар хэрэгжүүлэх үүргийг ажлын байрны тодорхойлолтод нь тусгасан байна.

172.65. Нөөц төлөвлөгөө

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэгийн аюулгүй, тасралтгүй, шуурхай ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй төхөөрөмжийн болон нислэгийнхөөлгөөний үйлчилгээний үйл ажиллагааны саатал, доголдол, түр хугацааны татгалзлын болон тэдгээрийг дэмжих үйл ажиллагааны үед хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөтэй байна.

172.67. Зохицуулалтын шаардлага

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэв хамааралтай бол хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НХҮ-ний нэгж болон дараах байгууллагын хоорондын зохицуулалтыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) ИНД-171-ийн дагуу олгосон НХНҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-173-ын дагуу олгосон ХНЖҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
- (3) ИНД-174-ийн дагуу олгосон НЦҮҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
- (4) ИНД-175-ын дагуу олгосон НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
- (5) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч;
- (6) Монгол Улсын Зэвсэгт хүчин;
- (7) эрэн хайх, авран туслах байгууллага;
- (8) хэрэв заасан НХҮ-ний нэгж нь аэродромын удирдлагын, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн нэгж бол:
 - (i) аэродромын үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл
 - (ii) хэрэв тухайн үйлчилгээг аэродромын удирдлагын нэгж гүйцэтгэдэггүй бол, аэрон зохицуулалтын үйлчилгээний нэгж.

(b) Хүсэлт гаргагч нь хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НХҮ-ний нэгж болон өөрт харъяалагдахгүй дараах салбарын хооронд НХҮ-ний гэрээ байгуулах журмыг тогтоосон байна:

- (1) хариуцлагын бүс нь шууд хиллэж байгаа зэргэлдээ НХҮ-ний нэгж;
- (2) байнгын харилцан зохицуулалт хийх шаардлагатай бусад НХҮ-ний нэгж.

- (с) НХҮ-ний гэрээнд дараах зүйлс туссан байх журамтай байна:
- (1) талуудын үр дүнтэй харилцан ажиллагааг зохицуулах журмыг тодорхой тусгасан байх;
 - (2) хүчинтэй байх;
 - (3) эрх бүхий удирдах албан тушаалтан баталж албажуулсан байх;
 - (4) байгууллагын үйл ажиллагааны ерөнхий журам, зааврын салшгүй хэсэг болж мөрдөгдөж байх.

(d) Хүсэлт гаргагч нь, НХҮ-ний нэгжийн хоорондын харилцаа холбооны хялбаршуулсан журам болон системээр хангасан байх үүрэгтэй. хэрэгсэлд тавих шаардлагыг хангасан холбооны системтэй байх ба харилцаа холбооны журмыг тогтоосон байна.

(e) Хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгж, агаарын хөлөг ашиглагч болон НЦУҮ-ний байгууллагатай нислэгийн хөдөлгөөний мэдээлэл солилцох зорилгоор дараах НХҮ-ний мэдээг түгээх, түүнийг хэрэгжүүлэх холбооны системтэй байна:

- (1) үндсэн ба нэмэлт өөрчлөлт орсон нислэгийн төлөвлөгөө;
- (2) нислэгийн хөдөлгөөний явцын талаарх мэдээлэл.

(f) Хүсэлт гаргагч нь CAVOK хэллэгийг ашиглахаас бусад тохиолдолд Doc 4444 (Part IX - Air Traffic Services Messages)-т заасан журмаар НХҮ-ний мэдээг бэлтгэж, түгээдэг байна.

172.69. Байгууламжийн статусыг мэдээлэх

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан байгууламж, эсхүл үйлчилгээний статуст орсон өөрчлөлтийн талаарх мэдээллээр НХҮ ашиглагчийг хангах журмыг тогтоосон байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлийг дэлгэрэнгүй тусгана:

- (1) Монгол Улсын AIP-ийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор ИНД-175-ын дагуу нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчид үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгөх;
- (2) байгууламж, эсхүл үйлчилгээний статусын түр хугацааны өөрчлөлт зэрэг NOTAM-ын үйлчилгээ үзүүлэх нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч мэдээгээр түгээхээс бусад агаарын навигацийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй саатал, өөрчлөлтийн талаарх мэдээллээр НХҮ ашиглагчийг шуурхай хангах.

172.71. Нислэгийн ерөнхий мэдээлэлд тавих шаардлага

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хариуцаж байгаа бүс дэх, нислэгт сөргөөр нөлөөлөх дараах мэдээллийг шуурхай хүлээн авах журмыг тогтоосон байна:

- (1) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил;
- (2) галт уулын дэлбэрэлт;
- (3) галт уулын үнст үүл;
- (4) агаарт цацах цацраг идэвхит материал болон хорт бодисын талаарх мэдээлэл.

(b) Хүсэлт гаргагч нь хариуцаж байгаа бүсэд НХҮ-ний нэгжийг тэдгээрийн хариуцлагын бүсэд хамааралтай дараах нислэгийн ерөнхий мэдээллээр хангадаг байна:

- (1) ил харааны бус навигацийн төхөөрөмжийн ашиглалтын байдал;
- (2) хөөрөлт, буултад ашиглах ил харааны хэрэгслийн ашиглалтын байдал;
- (3) газар дахь шилжилт хөдөлгөөний зохицуулалтад ашиглах ил харааны ба ил харааны бус хэрэгслийн ашиглалтын байдал.

(c) Дараах нэгжээс НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь уг нэгж нь хөдөлгөөнт талбай дахь онцгой нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүлээн авах журамтай байна. Уг мэдээлэлд түр зуурын аюул, аэродромын холбогдох байгууламжийн ашиглалтын нөхцөл байдал, горим багтсан байна:

- (1) аэродромын удирдлагын нэгж;
- (2) ойртолтын удирдлагын нэгж;
- (3) аэродромын нислэгийн мэдээллийн нэгж.

172.73. Цаг уурын мэдээлэл болон мэдээлэх

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, агаарын хөлөгт үзүүлэх нислэгийн мэдээллийн үйлчилгээнд цаг агаарын хүчинтэй мэдээлэл агуулагдахаар хангах тогтолцоог бүрдүүлэх ба уг тогтолцоо нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) цаг агаарын мэдээг ИНД-174-ийн дагуу гэрчилгээжсэн НЦҮҮ-ний байгууллагаас авч, баталгаажуулсан байх;
- (2) цаг агаарын мэдээ нь ИНД-174-ын 174.3 ба 174.6 заасны дагуу, нисэхийн цаг агаарын үндсэн мэдээ хэлбэрээр бэлтгэсэн байх.

(b) Хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгж үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг агаарын мэдээг НХҮ-ний ажилтны үйл ажиллагаанд хамгийн багаар нөлөөлж тасалдуулахгүй хэлбэрээр хангадаг байх тогтолцоотой байна.

(c) Хүсэлт гаргагч нь цаг агаарын үндсэн мэдээлэлд ашиглах төхөөрөмж нь дараах шаардлагыг хангах журамтай байна:

- (1) хэмжилт нь тухайн хариуцлагын бүсийн цаг уурын байдлыг бүрэн тодорхойлохуйц байх;

(2) хэд хэдэн салхины чиглэл, хурд хэмжигч, заагч, ХБЗ дээрхи алсын барааны харагдацыг илтгэх, агаарын температур, даралтыг заах хэмжүүр, хэмжих хэрэгслээс бүрдсэн төхөөрөмж байх.

(d) Хүсэлт гаргагч нь, мэдээллийн хуудас хэлбэрээр хүлээн авсан цаг агаарын мэдээг радио- холбоогоор түгээх үед ямар нэг алдаа гарах, буруу мэдээлэхээс сэргийлэх, хяналт тавих журмыг тогтоосон байна.

172.75. Бүсийн болон ойртолтын удирдлагын үйлчилгээ

(a) Бүсийн, эсхүл ойртолтын удирдлагын үйлчилгээний хувьд, НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үйл ажиллагааг зохицуулах тогтолцоо болон журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэлд тулгуурлан агаарын хөлөг хоорондын байрлал, харьцааг тодорхойлох;
- (2) агаарын зайн ангилал, нислэгийн төрлөөс хамааран нислэгийн хөдөлгөөний аюулгүй, шуурхай урсгалыг хангах зорилго бүхий НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх;
- (3) бусад НХУ-ын нэгжтэй зөвшөөрлийн харилцан зохицуулалт хийх;
- (4) шинжилгээ, дүгнэлт хийх зорилгоор зөвшөөрөл олгосон байдал, нислэгийн хөдөлгөөний явцын мэдээллийг хамтатгаж бэлтгэн үзүүлэх.

(b) Дараах нислэг хооронд, энэ зүйлийн (d) болон 172.91-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (a)(2)-т заасны дагуу, мөн энэ зүйлийн (c)-д заасныг баримтлан босоо ба хэвтээ, эсхүл хосолмол зайчлалыг хангах журмыг тогтоосон байна:

- (1) “А” ба “В” ангиллын агаарын зайд үйлдэж байгаа бүх агаарын хөлөг;
- (2) “С” ба “D” ангиллын агаарын зайд IFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
- (3) “С” ангиллын агаарын зайд IFR ба VFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
- (4) “В”, “С”, “D” ангиллын агаарын зайд IFR болон тусгай VFR-аар нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
- (5) “В”, “С”, “D” агаарын зайд, нислэгийн алсын барааны харагдаж 5 км-ээс бага тохиолдолд тусгай VFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;

(c) Энэ зүйлийн (b)-д шаардсан зайчлал нь дараах баримт бичигт заасан хамаарах шалгуур болон минима-д нийцсэн байх ёстой:

- (1) E Бүлэг; эсхүл
- (2) Хавсралт 11; эсхүл
- (3) Doc 4444; эсхүл
- (4) Doc 7030.

(d) “D” ба “E” ангиллын агаарын зайн хувьд IFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт НХУ-аар хангасан IFR-ээр нислэг үйлдэж байгаа бусад агаарын хөлөгтэй аюулгүй зайгаа өөрөө тодорхойлон хадгалах зөвшөөрөл, заавар олгосон тохиолдолд энэ зүйлийн (b)(2)-т заасан зайчлалыг баримтлах шаардлагагүй. Энэхүү зөвшөөрөл, зааврыг зөвхөн дараах нөхцөлд олгоно:

- (1) тухайн зөвшөөрөлийг агаарын хөлгийн нисгэгчийн тусгайлан гаргасан хүсэлтийн дагуу өгсөн;
- (2) нислэгийг зөвхөн өдрийн цагаар, ил харааны цаг уурын нөхцөлд үйлдэж байгаа;
- (3) **НХУ-ний бодит ажиглалтын** удирдлагын үйлчилгээ байхгүй бол;
- (4) зөвшөөрөл нь нислэгийн тухайлан заасан үе шатанд хүчинтэй байх;
- (5) зайчлалын энэхүү аргыг ашиглаж байгааг онцгой нислэгт тооцох бүх агаарын хөлөг зөвшөөрсөн байх;
- (6) зайчлалын уг аргыг ашиглаж байгаа талаар холбогдох бусад агаарын хөлөгт мэдээлсэн байх;
- (7) тухайн нислэг нь НХУ-ын ижил давтамжаар.

172.77. Аэродромын удирдлагын үйлчилгээ

(a) Аэродромын удирдлагын үйлчилгээ эрхлэх НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах тогтолцоо болон журмыг бүрдүүлсэн байна:

- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэл ба ил харааны хяналтад тулгуурлан агаарын хөлгийн хоорондын байрлал, харьцааг тодорхойлох;
- (2) дараах агаарын хөлөг өөр хоорондоо , эсхүл газар дахь саадтай мөргөлдөхөөс сэргийлэх зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх:
 - (i) аэродромын бүсэд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (ii) хөөрөлт, буулт үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (iii) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (iv) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлөг ба тээврийн хэрэгсэл, хүн
 - (v) маневрлах талбай дахь агаарын хөлөг ба саад.
- (3) нислэгийн хөдөлгөөний аюулгүй, шуурхай урсгалыг хангах зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх;
- (4) 172.91 болон 172.295-д зааснаас бусад тохиолдолд, ХБЗ-ны болон дагалдах хуйлралаас сэргийлэх зайчлалыг дараах баримт бичигт заасан шалгуур болон минима-гийн дагуу тогтоох:
 - (i) Хавсралт 11; эсхүл
 - (ii) Дос 4444; эсхүл
 - (iii) Дос 7030; эсхүл
 - (iv) E Бүлэг.

- (5) аюулд орсон , эсхүл аюул тулгарсан агаарын хөлөгт яаралтай тусламж үзүүлэх зорилготой тээврийн хэрэгсэл нь газрын бусад тээврийн хэрэгслээс давуу эрхтэй байх;
 - (6) маневрлах талбайд зорчиж байгаа хүн, тээврийн хэрэгсэл, чирүүлж байгаа агаарын хөлөг ба хөөрөлт, буулт, явгалалт үйлдэж байгаа агаарын хөлөг хоорондоо мөргөлдөх аюулаас сэргийлэн тогтмол хяналт тавьж байх;
 - (7) бусад НХҮ-ний нэгжтэй харилцан зохицуулалт хийж байх;
 - (8) НХҮ-ыг гүйцэтгэж байгаа тухайн ажлын байранд нислэгийн хөдөлгөөний явц, өөрчлөлтийн мэдээллийг тасралтгүй илтгэн үзүүлэх.
- (b) Хүсэлт гаргагч нь, агаарын хөлөгтэй харьцах радио-холбоогүй үед (a)-гийн (2)-д заасан агаарын хөлөгт зөвшөөрөл, заавар, мэдээллийг ИНД-91.243-д заасан гэрлэн дохиолол ашиглан түүнд заасны дагуу олгох журамтай байна.
- (c) Хүсэлт гаргагч нь цаг агаар, эсхүл ойртолтын зэрэглэл зэргээс хамаарч дараах журмыг тогтоосон байна:
- (1) ILS-аар ойртолт хийж байгаа агаарын хөлөг нь ILS-д нөлөөл орсон талаар, эсхүл магадлалын талаар мэдээлсэн байх
 - (2) Агаарын хөлөг ILS-д орсон, эсхүл ILS-д бусад нөлөөлөл үгүй байх ёстой ойртолтын тодорхой цэгт хүрсэн үед ILS нь нөлөөллөөс сэргийлсэн байх.
- (d) Хүсэлт гаргагч нь 172.91-д заасан болон холбогдох ойртолтын удирдлагын нэгжийн зөвшөөрсөн байхаас бусад тохиолдолд, аэродромын удирдлагын нэгж нь дараах нислэг хооронд зайчлал тогтоодог болохыг бататгах журмыг тогтооно:
- (1) IFR болон тусгай VFR;
 - (2) мэдээлэгдсэн нислэгийн алсын барааны харагдац 5 км-ээс бага бол, тусгай VFR.
- (e) Эрхийг шилжүүлсэн бөгөөд түүнийг зөвшөөрсөн бол, хүсэлт гаргагч нь холбогдох бүс, эсхүл ойртолтын удирдлагын нэгж, аэродромын удирдлагын нэгж нь тухайн шилжүүлсэн эрхийн дагуу хяналттай нислэгийн хоорондох зайчлалыг хангадаг болохыг бататгах журмыг тогтооно.
- (f) Энэ зүйлийн (d) болон (e)-д шаардсан зайчлалыг дараах баримт бичигт заасан шалгуур болон минима-гийн дагуу босоо, эсхүл хэвтээ, эсхүл хосолмол зайчлал ашиглан тогтооно:
- (1) Хавсралт 11; эсхүл
 - (2) Дос 4444; эсхүл
 - (3) Дос 7030; эсхүл
 - (4) E Бүлэг.

172.79. Тусгай зориулалтын агаарын зай

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 172.293-д заасан зайчлал хангагдах ёстой агаарын хөлөг ИНД-71-ийн дагуу тогтоосон идэвхитэй тусгай зориулалтын агаарын зайгаас дараах тохиолдолоос бусад үед зайчлах журмыг тогтоосон байна:

- (1) нисэх баг уг агаарын зайг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан;
- (2) аюултай бүс, эсхүл галт уулын аюултай зооны хувьд, нисэх баг уг бүсэд нислэг үйлдэх тухайгаа илтгэсэн;
- (3) аюултай бүсэд нислэг хийж байгаа агаарын хөлгийн нисэх баг VFR-ээр, эсхүл ил харааны баримжаа ашиглан IFR-ээр нисч байгаагаа илтгэсэн, эсхүл мэдэгдсэн;
- (4) нисэх баг уг агаарын зайгаас өөрөө зайчлалаа хадгалан нисэхээ илтгэсэн.

172.81. Удирдлагын хариуцлага

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, НХУ-аар хангаж байгаа нислэгийг нэгж хугацаанд зөвхөн нэг салбар, нэгжийн удирдлагаар хангах журмыг тогтоосон байна.

(b) Хүсэлт гаргагч нь, тогтоосон нэгж агаарын зайн бүс, сектор дахь нислэгийн хөдөлгөөний удирдлагыг зөвхөн нэг байр хариуцан гүйцэтгэх журмыг тогтоосон байна. Агаарын хөлөг, эсхүл бүлэг агаарын хөлгийн НХУ-ыг өөр ажлын байрны хариуцлагад нэгтгэхдээ зэргэлдээх ажлын байртай урьдчилсан харилцан зохицуулалт хийх журмыг мөрдөнө.

(c) Хүсэлт гаргагч нь агаарын хөлгийн удирдлагыг шилжүүлэх журамтай байна.

(d) Энэ зүйлийн (c) -д заасан журам нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) удирдлага шилжүүлэлтийг гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтлах:
 - (i) зэргэлдээх агаарын зайг хариуцдаг НХУ-ын нэгжтэй урьдчилан зөвшилцсөн ба НХУ-ний гэрээнд тусгасны дагуу явагдах;
 - (ii) НХУ-ын нэгжийн тусгаар ажлын байр хооронд гүйцэтгэх ба удирдлага шилжүүлэх зарчим нь тухайн салбар, нэгжийн үйл ажиллагааны зааварт тодорхой тусгасан байх.
- (2) дараах нөхцөлд НХУ-ын нэгжээс нөгөөд агаарын хөлгийн удирдлага шилжүүлэхийг хориглоно:
 - (i) нислэгийн төлөвлөгөөг бүхэлд нь , эсхүл түүний шаардлагатай хэсгийг урьдчилан дамжуулж мэдэгдээгүй;
 - (ii) НХУ-ын өгсөн зөвшөөрөл, захирамж гэх мэт шаардлагатай хавсралт мэдээлэлгүй;
 - (iii) удирдлага хүлээн авч байгаа талын зөвшөөрөлгүй үед.

172.83. Хөдөлгөөний эрэмбэ

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нисэхийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх аргахэмжээг авсан байна. НХУ-ын нэгж нь удирдлага, үйлчилгээгээр хангах дараах давуу эрх олгох журамтай байна:

- (1) аюулд орсон ба аюул тулгарсан агаарын хөлөг бусад агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
- (2) буултын эцсийн үе шатад яваа болон буулт үйлдэж байгаа агаарын хөлөг хөөрөлт үйлдэх агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
- (3) буулт, хөөрөлт үйлдэх агаарын хөлөг, явгалж байгаа агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;

(б) Хүсэлт гаргагч нь дараах нислэгт үйлчлэх тусгай журамтай байна:

- (1) эмнэлгийн яаралтай тусламж болон хүмүүнлэгийн тусламжийн тусгай үүргийн нислэг;
- (2) эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны тусгай үүргийн нислэг;
- (3) иргэний хамгаалалтын ба цагдаагийн шуурхай ажиллагааны тусгай үүргийн нислэг;
- (4) Монгол Улсын болон гадаад улсын төр засгийн тэргүүн, дээд хэмжээний зочин төлөөлөгчдөд үйлчлэх зорилгоор үйлдэж байгаа онцгой болон тусгай үүргийн нислэг.

(с) Хүсэлт гаргагч нь нислэгийн үндсэн түвшинг хадгалж яваа агаарын хөлөг, уг аяллын түвшнийг эзлэхээр хүсэлт гаргасан агаарын хөлгөөс давуу эрхтэй байх журмыг тогтоосон байна:

- (1) Агаарын хөлөгт аяллын түвшний давуу эрхийг олгохдоо Doc 7030, эсхүл НХУ-ний гэрээнд заасан журмыг баримтлах;
- (2) зайчлалыг хадгалах зорилгоор тухайн аяллын түвшнийг хадгалан нисч байгаа агаарын хөлөгт нислэгийн өөр түвшнийг эзлэх заавар өгсөн бол.

(д) Бүсийн удирдлагын үйлчилгээ эрхлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-71-ийн дагуу тогтоосон RNP агаарын зайн **хөдөлгөөний эрэмбийн** журамтай байна.

(е) Энэ зүйлийн (а) болон (б) заалтын дагуу, хүсэлт гаргагч нь сонирхогч талуудтай зөвшилцсөнийг үндэслэн хөөрөлт буултын эрэмбийг тодорхойлох бүдүүвчтэй байж түүнийг хэрэглэдэг байна.

(ф) Хүсэлт гаргагч нь (д) ба (е)-гийн дагуу эрэмбэ тогтоосон бөгөөд холбогдох мэдээллийг гомдол хэрхэн шийдвэрлэх журмын хамт Монгол Улсын AIP-д тусгасан байна.

(г) Хүсэлт гаргагч нь аюулгүй байдлыг алдагдуулалгүйгээр, аэродром ашиглагчтай хөдөлгөөний эрэмбийн дараах мэдээллийг харилцан мэдээлсэн байна:

- (1) аэродромд нисэн ирж байгаа болон нисэн гарч байгаа агаарын хөлөг;
- (2) аэродромын холбогдох удирдлагын зооны бусад үйл ажиллагаа.

(х) Хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн бусад зүйлийн дагуу агаарын хөлгийн эрэмбийг тогтоохоос бусад тохиолдолд түрүүлж ирсэн нь түрүүлж үйлчлүүлэх зарчмыг мөрдөнө.

(i) Хүсэлт гаргагч нь НХУ-ын үйлчилгээ дараах үйлчилгээнээс дээгүүр эрэмбэтэй байх журамтай байна:

- (1) нөхцөл байдал шаардаж байгаа нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (2) бусад НХУ-ний бус үүрэг.

172.85. Нислэгийн хөдөлгөөний урсгал зохицуулалт

(a) НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-ний тогтолцооны багтаамжийн болон аэродромын хүчин чадлын хязгаарлалт бий тохиолдолд нислэгийн хөдөлгөөний урсгалт зохицуулалтын журмыг тогтоосон байна.

(b) Журамд дараах зүйлсийг багтаана:

- (1) Холбогдох аэродромын шаардлага, тухайлбал нислэгт үйлчлэх эрэмбэ;
- (2) Нөлөөлөл үзүүлж болох агаарын тээвэрлэгч, бусад НХУ-ний байгууллагын хэрэгцээ шаардлага;
- (3) нисэхийн мэдээллийн үйлчилгээний шаардлага, түүний дотор урьдчилан мэдэгдэх шаардлага, идэвхжүүлэх болон иднвхигүй болгох талаарх мэдээлэл.

172.87. НХУ-ын зөвшөөрөл

(a) НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-ын зөвшөөрөл олгох журмыг тогтоосон байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлийг тусгана:

- (1) НХУ-ын зөвшөөрөл, заавар нь нисэх баг хүчинтэй бусад хууль дүрмийг зөрчихөд хүргэхээргүй байх;
- (2) зөвшөөрөл, зааврыг алдаа мадаггүй, тодорхой, стандарт хэлбэрээр олгох;
- (3) нисэх баг өгсөн зөвшөөрөл ба зааврыг биелүүлэх боломжгүй тухайгаа илтгэсэн тохиолдолд, хэрэв боломжтой бол зөвшөөрөл, зааварт зохих өөрчлөлтийг оруулж дахин олгох;
- (4) нислэгийн замын НХУ-ын зөвшөөрөл нь дараах мэдээллээс бүрдэнэ:
 - (i) агаарын хөлгийн нислэгийн төлөвлөгөөнд тусгасан дуудлага;
 - (ii) зөвшөөрөл үйлчлэх хязгаар, цэг;
 - (iii) нислэгийн зам;
 - (iv) бүх нислэгийн зам, эсхүл түүний хэсэгт хадгалах түвшин, түүний өөрчлөлт; нисэн гарах, ойртолт үйлдэх тогтоосон бүдүүвч, зөвшөөрлийн хүчинтэй үйлчлэх хугацаа гэх мэт бусад заавар, мэдээлэл;
 - (v) any necessary instructions or information on other matters such as approach or departure manoeuvres, communications, and the time of validity or expiry of the clearance; and
- (5) тухайн орон нутаг, түүний тодорхой нэг бүсэд үйлдэх нислэгт олгох НХУ-ын зөвшөөрөлд энэ хэсгийн (4)-т заасан зүйлийн аль тохирохыг багтаан олгоно.

- (6) Дуунаас хурдан агаарын хөлгийн хувьд НХУ-ын зөвшөөрөл нь:
- (i) Дуунаас хурдлах хурдатгалын үе шатны төгсгөл хүртэл байна;
 - (ii) Дуунаас хурдан нислэгээс дууны хүрээн дэх нислэгт шилжих хурдны бууралтын үеийн тасралтгүй өндөр алдалтыг заана.

172.89. Аяллын нислэгийн түвшин

(a) Дараахаас бусад тохиолдолд НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, Улаанбаатарын нислэгийн мэдээллийн районы хүрээнд IFR-ээр үйлдэх нислэгийн хувьд ИНД-91.425, VFR-ээр үйлдэх нислэгийн хувьд ИНД-91.313-д заасан аяллын түвшнийг сонгох журмыг тогтоосон байна:

- (1) IFR ба VFR-ийн нислэгт, тэдгээрийн аяллын түвшний харьцаа, нислэгийн чиг шардлагагүй.
- (2) VFR-ээр үйлдэх нислэгт IFR-ын түвшинд нисэх зөвшөөрөл олгосон;

172.91. НХУ-ын зөвшөөрлөөс хазайх

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нисэх баг дараах зайлшгүй шалтгаанаар нисэх багийн үйлдэлд хориг үл тавих, аюулгүй байдалд нийцсэн захирамж өгөх талаар мөрдөх журамтай байна:

- (1) агаарын хөлөг ACAS системийн зөвлөмжийг даган маневр үйлдэх; эсхүл
- (2) GPWS ба TAWS-ын дохиоллоор үйлдэл хийх, эсхүл
- (3) цаг агаар, эсхүл ослын нөхцөл байдлын улмаас НХУ-ын зөвшөөрлөөс хазайх.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд, аюулаас зайлах маневр гүйцэтгэсний дараа нислэгийн зайчлалыг нэн даруй эргүүлэн тогтоохоор тусгана.

172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ**Ерөнхий зүйл**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, дараах нөхцөлд агаарын хөлгийг нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангахад мөрдөх журмыг тогтоосон байна:

- (1) Бүх агаарын хөлөг НХУ-ын үйлчилгээгээр хангаж байгаа бөгөөд энэ зүйлийн (b)-д заасан нислэгийн мэдээллийн үйлчилгээ шаардлагатай.
- (2) агаарын хөлөг аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангаж байгаа болон энэ зүйлийн (b)-д заасан үйлчлгээгээр хангах шаардлагатай; эсхүл
- (3) агаарын хөлөг IFR-ээр нислэг үйлдэж байгаа ба нислэгийн мэдээллийн үйлчилгээ шаардлагатай; эсхүл
- (4) агаарын хөлөг VFR-ээр нислэг үйлдэх ба НХУ-ний нэгжид VFR-ннр нисэх нислэгийн төлөвлөгөө бөглөн ирүүлсэн;
- (5) НХУ-ний нэгжээс агаарын хөлөг VFR-ээр нислэг үйлдэх ба нислэгийн мэдээлэл авахыг хүссэн.

(b) Хүсэлт гаргагч нь нислэгийн мэдээлэлд нь дараах зүйл багтах журамтай байна:

- (1) SIGMET мэдээ;
- (2) нисэн гарах, буулт үйлдэх ба бэлтгэл аэродромын цаг агаарын бодит ба урьдчилсан мэдээ;
- (3) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил, галт уулын дэлбэрэлт, галт уулын үнст үүлийн талаарх мэдээлэл
- (4) агаарт дэгдэн цацагдсан цацраг идэвхит бодис, хорт бодисын талаарх мэдээлэл
- (5) навигацийн төхөөрөмжийн ажиллагааны горим, ашиглалтын өөрчлөлтийн мэдээ;
- (6) аэродром, газрын хөдөлгөөний бүс ба түүний орчмын цас, мөс, усны байдал зэргийг багтаасан аэродром болон холбогдох байгууламжийн нөхцөлд орсон өөрчлөлтийн мэдээ;
- (7) жолоочгүй агаарын бөмбөлгийн талаарх мэдээлэл
- (8) нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

(c) Аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ХБЗ дээр ус байгаа эсэх, ХБЗ-ын өргөний төвийн хагасын нөхцөлийг дараах аль нэг нөхцөлийг ашиглан тодорхойлохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) DAMP , эсхүл ЧИЙГТЭЙ - зурвас чийгтэй болсноос өнгө нь өөрчлөгдсөн;
- (2) WET , эсхүл НОЙТОН - зурвас норсон боловч гадарга нь ус тогтоогүй;
- (3) WATER PATCHES , эсхүл ТОГТООЛ - зурвас дээр хэсэгчлэн тогтсон ус ажиглагдсан;
- (4) FLOODED , эсхүл YEP - зурвас их хэмжээний үерлэсэн усаар бүрхэгдсэн.

(d) Аэродромын удирдлагын үйлчилгээ, ойртолтын удирдлагын үйлчилгээ, эсхүл, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэв тэд бусад эх үүсвэрээс мэдээлэл авах боломжгүй бол үйлчилгээний хэвлэн нийтлэгдсэн цагийн гэнэтийн өөрчлөлтийг үйл ажиллагаанд нь нөлөөлж болох агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид боломжтой тохиолдолд мэдээлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл

(e) НХУ эрхлэх НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой анхаарах нислэгийн хөдөлгөөний мэдээллийг түүний ойролцоох агаарын хөлөгт мэдээлэх журамтай байна.

(f) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, дараах агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний мэдээлэл өгөх журамтай байна: НХУ-ний нэгж НХУ-ний нэгж

- (1) “С” ангиллын агаарын зайд VFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт, нисэх баг хүсэлт гаргасан тохиолдолд аюултай ойртолтоос зайлах зөвлөмжийн хамт;
- (2) “D” ангиллын агаарын зайд IFR ба VFR-ээр үйлдэж байгаа нислэгт, нисэх баг хүсэлт гаргасан тохиолдолд аюултай ойртолтоос зайлах зөвлөмжийн хамт;
- (3) “E” ангиллын агаарын зайд, хэрэв боломжтой бол IFR ба VFR-ээр үйлдэж байгаа нислэгт, нисэх баг хүсэлт гаргасан тохиолдолд аюултай ойртолтоос зайлах зөвлөмжийн хамт
- (4) “G” ангиллын агаарын зайд IFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт нисэх багийн хүсэлтээр.

172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ

(a) Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аэродромын нислэгийн мэдээллийг дараах хэлбэрээр өгөх журамтай байна:

- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэлд тулгуурлан агаарын хөлөг хоорондын байрлалыг харьцуулан тодорхойлох;
- (2) нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах зөвлөмж, мэдээлэл өгөх:
 - (i) аэродром орчмын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (ii) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (iii) буулт, хөөрөлт үйлдэж байгаа агаарын хөлөг;
 - (iv) маневрлах талбай дахь агаарын хөлөг, газрын тээврийн хэрэгсэл, хүмүүс;
 - (v) маневрлах талбай дахь агаарын хөлөг ба түүн дээрх саад.

(b) Хүсэлт гаргагч нь, хөөрөлт буултад ашиглахаар сонгосон ХБЗ нь тухайн төрлийн нислэг, агаарын хөлөгт нийцсэн болохыг бататгах журмыг тогтоосон байна.

172.97. Анхааруулах үйлчилгээ

(а) Энэ дүрэмд агаарын хөлөгт аюул тулгарсан, эсхүл аюулд орсон нөхцөлд дараах агуулгыг илтгэх нэгдсэн нэр томъёог хэрэглэнэ

INSERFA - Тодорхойгүй үе;

ALERFA - Түгшүүрийн үе;

DETRESFA - Аюулын үе;

RCC - Эрэн хайх, авран туслах (цаашид ЭХАТ гэх) зохицуулах төв.

(b) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, өөрийн хариуцлагын бүсэд дараах агаарын хөлгийг анхааруулах үйлчилгээгээр хангах журам тогтоосон байна:

(1) аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд, бүх аэродромын нислэгийн хөдөлгөөнд;

(2) дараах бүх агаарын хөлөгт:

(i) ИНД-91-ийн 91.307, 91.407-д заасны дагуу нислэгийн төлөвлөгөө ирүүлсэн; эёхүл

(ii) Яаралтай НХҮни йтусламж шаардлагатай болохоо илтгэсэн;

(iii) хууль бус халдлагад өртсөн өуюу өртсөн байж болзошгүй нөхцөл үүссэн;

(c) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (f)-д тодорхойлсон аюулын нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх дараах арга хэмжээний журмыг тогтоосон байна:

(1) энэ зүйлийн (e)-д заасны дагуу INCERFA, ALERFA, DETRESFA үе шатыг зарлах;

(2) орон нутгийн авран туслах байгууллагын ажиллагаагаар зохицуулахаас бусад тохиолдолд, зарласан аюулын тухай мэдээллийг бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв ба нислэгийн мэдээллийн төвд яаралтай мэдэгдэх.

(d) Бүсийн удирдлагын үйлчилгээ, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэгийн онцгой тохиолдол болон онцгой нөхцөлийн үе дэх бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төвийн ажиллагааг зохицуулах дараах журмыг тогтоосон байна:

(1) UB FIR-ын хүрээнд аюулын нөхцөл байдлын талаархи бүх мэдээллийг цуглуулах үндсэн, төв зангилаа хэлбэрээр ажиллах;

(2) энэ зүйлийн (l)(1)-д зааснаас бусад тохиолдолд, цуглуулсан мэдээллийг ЭХАТ зохицуулах төвд яаралтай дамжуулах.

(e) Энэ зүйлийн (c)-г үл харгалзан, аэродромын удирдлагын үйлчилгээ, ойртолтын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, нөхцөл байдал яаралтай үйл ажиллгаа шаардсан тохиолдолд, тухай үйлчилгээг зохих орон нутгийн онцгой байдлыг зохицуулах байгууллагад эхний анхааруулах мэдээллийг өгдөг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (c)-д заасан аюулын үе шатыг дараах нөхцөлд , эсхүл агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд ямар нэг эргэлзээ байхгүйгээс бусад тохиолдолд зарлана:

(1) INSERFA , эсхүл Тодорхойгүй үе:

- (i) IFR, эсхүл хяналттай VFR-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг холбоо барих тооцоот цагаасаа хойш 15 минутын хугацаанд радио-холбоо бариагүй, эсхүл агаарын хөлөгтэй холбоо тогтоохоор хийсэн оролдлого үр дүнгүй болсон тохиолдолд аль болох эрт; эсхүл
 - (ii) Нисэх баг нислэгийн төлөвлөгөөгө цуцлаагүй, эсхүл SARTIME зарлаж мэдэгдээгүй, агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох оролдлого үр дүнгүй болсон, эсхүл
 - (iii) нислэгийн төлөвлөгөөнд VFR-ээр нислэг үйлдэхээр тусгасан ба SARTIME зарлаагүй агаарын хөлөг нисэн ирэх тооцоот цагаасаа хойш 30 минутын хугацаанд ирээгүй тохиолдолд; эсхүл
- (2) Агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд илт аюул тулгарснаас бусад тохиолдолд, ALERFA , эсхүл Түгшүүрийн үеийг (ii), (iii), (iv)-ийн хувьд агаарын хөлөг, түүгээр зорчигчдын амь нас эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн нотолгоо байгаагаас бусад нөхцөлд:
- (i) агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус халдлагад өртсөн нь тогтоосон үед; эсхүл
 - (ii) тодорхойгүй үеийн дараагийн шатанд холбоо алдагдсан агаарын хөлөгтэй боломжтой бүх сувгийг ашиглан холбоо тогтоох нэмэлт арга хэмжээ үр дүнд хүрээгүй , эсхүл уг агаарын хөлгийн талаар ямар нэг мэдээлэл ирээгүй тохиолдолд; эсхүл
 - (iii) тооцоот цагаасаа хойш 5 минутын хугацаанд буулт үйлдээгүй ба дахин холбоо тогтоогоогүй тохиолдолд; эсхүл
 - (iv) агаарын хөлөгт ямар нэг эвдрэл, ажиллагааны доголдол гарсан тухай илтгэсэн боловч аргагүйдсэн буулт үйлдэх шаардлага тулгараагүй нөхцөлд.
- (3) агаарын хөлөг, бүхээгт байгаа хүмүүст шууд аюул тулгараагүй нь тогтоогдсоноос бусад тохиолдолд, DETRASFA , эсхүл Аюулын үе:
- (i) түгшүүрийн үеийн дараагийн шатанд радио-холбоо алдагдсан агаарын хөлөгтэй холбоо тогтоох бүх оролдлого амжилтгүй болсон ба агаарын хөлөг аюулд орсон магадлал ихэссэн;
 - (ii) тооцоогоор агаарын хөлгийн түлш дууссан, эсхүл аюулгүй буулт үйлдэх хангалттай түлшгүй нь тогтоогдсон;
 - (iii) агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэхээс өөр аргагүй байдалд хүргэх техник төхөөрөмжийн татгалзал, ажиллагааны доголдол тулгарсан тухай мэдээлэл ирсэн;
 - (iv) агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдсэн нь тогтоогдсон нөхцөлд.
- (g) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (c)(2)-т заасан шаардлагын дагуу аюулын мэдэгдлийг дараах дэс дарааллаар олгох журмыг тогтоосон байна:
- (1) аюулын нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй, түгшүүрийн, аюулын үе шатыг зарлах;
 - (2) аюулын нөхцөл зарлаж байгаа салбар, ажилтны нэр , эсхүл дуудлага;
 - (3) аюулын төрөл;
 - (4) нислэгийн төлөвлөгөөнд тусгасан чухал мэдээлэл;

- (5) хамгийн сүүлд холбоо тогтоосон салбар, нэгжийн дуудлага, холбоо тогтоосон давтамж;
 - (6) агаарын хөлгийн хамгийн сүүлийн байрлал илтгэлт болон байрлалыг хэрхэн тогтоосон тухай тайлбар;
 - (7) агаарын хөлгийн өнгө, таних тэмдэг;
 - (8) мэдээлж байгаа салбараас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйлдэл.
- (h) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюулын мэдэгдлийн дараагийн шатанд ЭХАТ төвийг дараах мэдээллээр шуурхай хангах журмыг тогтоосон байна:
- (1) шаардлагатай нэмэлт мэдээлэл;
 - (2) аюулын нөхцөл байдал төгсгөл болсон тухай мэдэгдэл.
- (i) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюулд орсон, эсхүл аюул тулгарсан агаарын хөлөгтэй холбоо барих болон байрлалыг тодорхойлоход шаардлагатай холбоо харилцаа, ажиглалтын боломжит бүх хэрэгслийг ашиглах журмыг тогтоосон байна.
- (j) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюул тулгарсан байж болзошгүй агаарын хөлгийн мэдэгдэж байгаа хамгийн сүүлийн байрлал нь бүртгэгдсэн, тэмдэглэгдсэн байх журмыг тогтоосон байна.

(к) хамааралгүй

- (l) Бүсийн удирдлагын үйлчилгээ, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:
- (1) бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв ба нислэгийн мэдээллийн төв Тодорхойгүй, эсхүл Түгшүүрийн үеийг зарлаж байгаа тохиолдолд ЭХАТ төвд мэдэгдэхээс өмнө бололцоотой бол тухайн агаарын хөлгийг эзэмшигчтэй харилцаж тодруулга хийсэн байх;
 - (2) бололцоотой бол, ЭХАТ төвд мэдээлсэн бүх мэдээллээр тухайн агаарын хөлгийг эзэмшигчийг хангах.

172.99. Нислэгийн төлөвлөгөө

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах, түүний дагуу үйлчилгээгээр хангах журмыг тогтоосон байна.
- (b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан НХҮ-ний нэгжийн хүлээн авсан нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах журамд нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах дараах ерөнхий зарчмыг тусгасан байна:
- (1) нислэгийн төлөвлөгөө нь зохих маягтын дагуу, шаардлага хангаж байгаа эсэхийг нягтлах
 - (2) нислэгийн төлөвлөгөө нь бүрэн бөглөсөн ба шаардлагатай мэдээллийг агуулсан эсэхийг хянах;
 - (3) нислэгийн төлөвлөгөөг НХҮ-ний байгууллага хүлээн авах ерөнхий шаардлагыг хангасан байх.
- (c) Хоёр, эсхүл түүнээс дээш байрлалаас НХҮ-ний үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч нь өөр бусад нэгжийн өмнөөс нислэгийн төлөвлөгөө хүлээн авах нэг НХҮ-ний нэгжийг томилж болно.

(d) НХҮ-ний хүрээнд төвлөрсөн нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт зохицуулалтын үйлчилгээ эрхлэх НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь уг төвлөрсөн нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт зохицуулалтын байр дараах зүйлээр тоногдсон болохыг бататгана:

- (1) агаарын тээвэр эрхлэгч болон НХҮ-ний нэгжээс нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах AFTN, факс, мэдээлэл солилцооны компьютерийн сүлжээ зэрэг харилцаа холбооны байгууламж;
- (2) нислэгийн стандарт ба давтагдах төлөвлөгөөг урьдчилан оруулах, идэвхжүүлэх ажиллагаанд зориулсан байгууламж.

172.101. Цаг

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, НХҮ-ний нэгжид ашиглах цаг хугацааны хэмжүүрт тавих дараах шаардлагыг хэрэгжүүлсэн байна:

- (1) UTC-гийн 00:00 цагаас тооцоолол нь эхлэн, цаг минут секундын нэгжээр 24 цагийн үечлэлтэйгээр илэрхийлэгдэх Ертөнцийн Үндсэн Цаг (UTC)-ийг хэрэглэх;
- (2) UTC цагаас 5 секундээс илүү зөрүүгүй байх, цагийн тохиргоо нь стандарт цаг хугацааны станцын цагтай харьцуулан хийгдэж байх;

(b) Хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг өгөхдөө хагас минутын нарийвчлалтай зөв цагийг мэдээлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний хувьд, тухайн нисгэгч бусад эх үүсвэрээс авахаар зохицуулалт хийснээс бусад тохиолдолд, IFR-ийн агаарын хөлөг хөөрөлт үйлдэхээр явгалж эхлэхийн өмнө;
- (2) хүсэлт гаргасан бүх агаарын хөлөгт.

172.103. Өндөр хэмжигчийг тохируулах журам

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өндрийн хэрэглэлийн даралтын тохируулга хийх дараах журмыг тогтоосон байна:

- (1) QNH даралтын тохируулга нь гектопаскаль нэгжээр, хамгийн ойр бүхэл утгаар илэрхийлэгдэх;
- (2) тухайн аэродромын болон бүсийн QNH зооны өндөр-хэмжигчийн тохируулгыг анхлан холбоо тогтоож байгаа бүх агаарын хөлөг, түүний дотор ATIS мэдээ хүлээн авсан агаарын хөлөгт мэдээлэх;
- (3) НХҮ-ний нэгж агаарын хөлөг хүсэлт гаргасны дагуу тухайн аэродромын болон бүсийн QNH зооны өндөр-хэмжигчийн тохируулгыг мэдээлэх.

172.105. Радио холбооны журам

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь харилцаа холбооны дараах журмыг тогтоосон байна:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан, радио болон телефон утсан харилцааны стандарт хэллэгийг ашиглах;
- (2) зөвхөн НХҮ-тэй холбоотой , эсхүл нислэгийн аюулгүй байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг дамжуулах холбооны дэглэмийг тогтоосон байх;
- (3) дараахаас бусад тохиолдолд холбоо барих журмыг Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын 2 дугаар дэвтэрт заасны дагуу боловсруулсан байх:
 - (i) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн ИНД-91.249-д заасан шаардлагын дагуу дуудлага хэрэглэж байгаа;
 - (ii) Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа нэгж дуудлагадаа радио- холбооны “Мэдээллийн үйлчилгээ” дагаврыг хэрэглэх.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн зорилгоор стандарт хэллэг, түүнийг ашиглах нөхцөл нь дараах баримт бичигт нийцэж байгааг бататгана:

- (1) F Бүлэг
- (2) Хавсралт 10
- (3) Дос 4444
- (4) Дос 9432

(c) Энэ зүйлийн (b)-д заасан баримт бичиг өөр хоорондоо зөрчилдвөл энэ хэсэгт заасан дарааллын дагуу тодорхой нэг хэллэгийг сонгоно.

172.107. НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээ

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний бодит ажиглалтын систем ашиглан удирдлага, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна:

- (1) НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээг дараах баримт бичигт заасны дагуу үзүүлэх:
 - (i) Дос 4444; эсхүл
 - (ii) Дос 7030 (Ойрхи Дорнод/Азийн бүсэд хэрэглэх байдлаар нь; эсхүл
 - (iii) G Бүлэг.
- (2) Хоёрдогч радио-локаторын кодчилол нь ICAO-гийн Агаарын навигацийн төлөвлөгөөнд (ICAO Air Navigation Plan) заасан стандартад нийцэж байх;
- (3) Хоёрдогч радио-локаторын код ашиглах төлөвлөгөө нь дотоодын нислэгт дараах шаардлагыг хангахуйцаар бэлэн байх.
 - (i) Дос 4444-т заасан зарчмыг хангаж байх;
 - (ii) ИНД-91.247(а)-д заасан хүснэгттэй зөрчилдөхгүй байх.
- (4) дараах бүрэн мэдээллийг нисэх баг, агаарын хөлөг ашиглагчид өгсөн байх:
 - (i) НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээний төрөл, цар хүрээ;
 - (ii) НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээний хязгаарлалт.
- (5) НХҮ-ний бодит ажиглалтын үйлчилгээний талаарх мэдээлэл НХҮ үзүүлэх ажлын байранд байршсан байна.

172.109. Агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон тогтмол бус үйл ажиллагаа

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюулд орсон, эсхүл аюул тулгарсан агаарын хөлөгт боломжтой бүх туслалцааг үзүүлэх, давуу эрх олгох журмыг тогтоосон байна.

(b) Хүсэлт гаргагч нь шаардлагатай тохиолдолд төөрсөн, үл танигдах нислэг, улсыг батлан хамгаалах салбарын зэвсэгт хүчинд албадан саатуулагдсан агаарын хөлөгт туслалцаа үзүүлэх журмыг тогтоосон байна.

172.111. Ноцтой зөрчил, эсхүл ослын дараах арга хэмжээ

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, осол сүйрлийн дараа авч хэрэгжүүлэх ажиллагааны талаар дараах журмыг тогтоосон байна:

- (1) осол сүйрэлд аливаа навигацийн байгууламж нөлөөлсөн эсэхийг нягтлан шалгах;
- (2) дараах яаралтай арга хэмжээг авах:
 - (i) тухайн байгууламжийг ашиглаж байгаа болон ашиглахыг завдаж байгаа бусад агаарын хөлөгт анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх;
 - (ii) байгууламжийн ажиллагаа хэвийн бус байгаа талаар ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан байгууллага, мэргэжилтэнд шуурхай мэдэгдэх.
- (3) байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгчид хэвийн ашиглалт нь алдагдсан тухайн төхөөрөмжийн ажиллагааг яаралтай зогсооход туслах;
- (4) ИНД-171-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас зөвшөөрөл өгөх хүртэл (1)-д заасан аливаа байгууламжийг IFR-ээр үйлдэх нислэгийн хооронд аюулгүй зай бариулах зорилгоор ашиглахгүй байх.

172.113. Зөрчил

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь зөрчлийг илтгэх, мэдээлэх талаар дараах журмыг тогтоосон байна:

- (1) зөрчлийн тухай илтгэл, мэдээлэл ажиллагааг ИНД-12-ын дагуу гүйцэтгэх;
- (2) ИНД-91.431-д шаардсан байгууламжийн доголдлын мэдээг холбогдох НХНҮ-ний байгууллагад дамжуулах.

172.115. Бүртгэл хөтлөх

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах зорилгод ашиглах бичлэгийг тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, баримттай танилцах эрх олгох болон устгах журмыг тогтоосон байна:

- (1) НХҮ-ний ажиллагааг шалгах;
 - (2) осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг болох.
- (b) (а)-д заасан илтгэл нь дараах зүйлсийн агуулна:
- (1) телефон утсан холбооны яриа;
 - (2) радио-холбооны яриа ба нэвтрүүлэг;
 - (3) агаар-газрын тоон өгөгдлийн солилцоо;
 - (4) НХҮ-ний бодит ажиглалтын системийн өгөгдөл;
 - (5) нислэгийн үндсэн ба давтагдах төлөвлөгөө;
 - (6) нислэгийн хөдөлгөөний стрип;
 - (7) ээлжийн хуваарь;
 - (8) ижил хугацаанд Цаг уурын ба Нисэхийн мэдээлэл хангалтын байгууллагад хадгалагддаггүй тохиолдолд, цаг агаарын болон агаарын навигацийн холбогдолтой нисэхийн мэдээ;
 - (9) 172.123-д заасан чанарын дотоод хяналт шалгалт, дүгнэлтийн хуулбар, дүгнэлтэд шалгалт хийсэн тухай дэлгэрэнгүй тайлан, түүний мөрөөр залруулсан ажиллагаа, анхааруулгыг тус тус хавсаргана.
 - (10) дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан, сургалт дадлагад хамрагдсан байх шаардлагатай бүх ажилчдын түүх:
 - (i) хамрагдсан сургалт дадлага тус бүрийн намтар;
 - (ii) мэдлэгээ шалгуулсан тест, ур чадварын үнэлгээ зэрэг сургалтын шалгатын дүн.
- (c) Хүсэлт гаргагч нь дараах зүйлийг цахим бичлэгээр баримтжуулах журмыг тогтоосон байна:
- (1) НХҮ-ний радио болон телефон утсан харилцаа;
 - (2) богино долгионы радио-холбооны харилцаа;
 - (3) НХҮ-ний бодит ажиглалтын систем нь НХҮ-ын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх хоёрдогч ба анхдагч радио-локатор, бодит ажиглалтын бусад системийн өгөгдөл;
 - (4) удирдлагыг шилжүүлэх, хүлээн авах харилцан зохицуулалт хийх төхөөрөмжийн өгөгдөхүүн.

- (d) Энэ зүйлийн (c)-д заасан цахим бичлэг нь дараах шаардлагыг хангасан байна:
- (1) бичлэгийн хугацаа ба UTC цагийн зөрүү 5 секундээс хэтрэхгүй байх, GPS, эсхүл өөр стандарт цагтай харьцуулан тохиргоо хийгдсэн байх;
 - (2) бичлэг нь дуу болон дүрсийг үнэн зөв хуулбарласан байх;
 - (3) (2)-д заасан бичлэгийн ялгааг тодорхойлсон мэдэгдэл.
- (e) (d)(2)(ii)-г дурдсан зорилгоор радио-локаторын зураглал, агаарын хөлгийн байрлалын дүрслэлийг хадгалсан байна.
- (f) (d)(2)(i)-д заасан нөхцөл нь энэ Дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж эхлэх өдөр ашиглагдаж байсан төхөөрөмжид хамаарна.
- (g) Хүсэлт гаргагч нь (d)-гийн (2)-д зааснаас бусад бичлэг нь мэдээллийг уншиж болохуйц цэвэр ойлгомжтой байх журам тогтолцоог бүрдүүлсэн байна.
- (h) Хүсэлт гаргагч нь дараахаас бусад, (b)-д заасан бичлэгийг 31 хоногийн хадгалах журамтай байна:
- (1) 2 жилээс доошгүй хугацаагаар хадгалах ээлжийн хуваарь
 - (2) 172.121(a) (2) болон (3)-д заасан, 2 жил хадгалагдах бичгэн илтгэл
 - (3) тухайн ажилтны 2 жил хүртэл хугацаагаар хадгалах сургалт дадлагын бүртгэл намтар.

172.117. Бүртгэлийн дэвтэр болон ажлын байрны бүртгэл

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн НХҮ-ний нэгжийн ажлын байр бүр ээлжийн бүртгэлтэй, бүртгэл нь ажлын байранд хадгалагддаг, бүртгэлийн хуудас нь зөв дэс дарааллаар дугаарлсан байна.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан бүртгэлийг хөтлөх ажиллагаанд дараах шаардлагыг мөрдөнө:

- (1) ээлжийн бүртгэлийг ээлжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж байгаа ээлжийн ахлагч, эсхүл гүйцэтгэх албан тушаалтан хариуцах;
- (2) ээлжийн хугацаанд ажлын байранд хадгалах;
- (3) бүртгэл хийгдсэн хугацаа тэмдэглэгдэх;
- (4) бүртгэлийг дараагийн ээлжинд шилжүүлэхдээ бүртгэлийн үнэн зөвийг магадлан харилцан хүлээлцсэн тэмдэглэл хийж гарын үсэг зурсан байх;
- (5) бүртгэл нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (i) он сар өдөр, цаг хугацааны зөв дараалалтай, тосон бал, эсхүл бэхээр бичих;
 - (ii) баллаж давхардуулаагүй, гаргацтай;
 - (iii) алдаатай бичиглэлийг тэмдэглэл үйлдэн залруулах ба залруулга хийсэн этгээд гарын үсгээ зурсан.
- (6) бүртгэл хөтөлж эхэлсэн ба дууссан хугацааг тэмдэглэсэн байх, цагийн зөрүү байгаа бол түүний шалтгааныг дурдсан байна;
- (7) бүртгэлийн дэвтрийг дууссан өдрөөс нь хойш 3 жилээс багагүй хугацаагаар хадгална.

(c) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (а)-д заасан ээлжийн бүртгэлд тусгаагүй мэдээллийг бүртгэх ажлын байрны бүртгэлтэй байна.

(d) Ажлын байрны бүртгэлд дараах тэмдэглэлийг хийх журамтай байна:

- (1) дараах шаардлагатай мэдээлэл агуулагдсан байх:
 - (i) ажлын байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн хугацаа;
 - (ii) тухайн ажлын байрнаас эрхлэн явуулсан үйлчилгээний төрөл;
 - (iii) ажил үйлчилгээ гүцэтгэсэн ажилтан.
- (2) ажлын байрны бүртгэлийг үйлдсэн өдрөөс хойш 31 хоногоос багагүй хугацаагаар хадгална.

172.119. Аюулгүйн хамгаалалт

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртэй байна.

(b) Хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа НХҮ-ний нэгж, НХҮ-ний аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт аливаа эвдрэл сүйтгэл, саатал, хохирол учрах, улмаар агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгах зорилгоор **аюулгүйн хамгаалалтын бодит** шаардлага, сургуулилт бэлтгэлжилт, журмыг тусгасан байна.

(c) Энэ зүйлийн (b)-гийн ерөнхий хязгаарлалтыг үл харгалзан, аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь **аюулгүйн хамгаалалтын бодит** шаардлага, сургуулилт бэлтгэлжилт, журмыг **дараах зүйлийг тусгана**:

- (1) НХҮ-ний байгууламж, ажлын байранд зөвхөн эрх олгосон этгээд нэвтрэх;
- (2) үүрэг гүйцэтгэж байгаа ажилтныг хамгаалах;
- (3) НХҮ-ний нэгжийн эсрэг тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, хууль бус халдлага хийх оролдлогын үед хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, горим;
- (4) НХҮ-ний нэгжид хууль бусаар нэвтрэх, үйл ажиллагаанд нь саад хийх үйлдлийг илрүүлэх зорилгоор тогтмол хяналт тавих.

172.121. Үйлчилгээний саатал

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-12 дүрэмд нэмэлт болгон дараах журмыг тогтоосон байна:

- (1) нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй НХҮ-ний урьдчилан төлөвлөсөн аливаа саатал, түр зогсолтын талаар Даргад мэдэгдэх;
- (2) урьдчилан төлөвлөгдөөгүй гэнэтийн саатал, түр зогсолтыг шалгах, шалтгааныг тогтоох;
- (3) урьдчилан төлөвлөгдөөгүй гэнэтийн саатал, түр зогсолтын үеийн нөхцөл байдал, түүнээс шалтгаалан нисэхийн хөдөлгөөний аюулгүй байдалд тулгарах сөрөг нөлөөллийн талаар Даргад 48 цагийн дотор мэдээлэх.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан саатал, түр зогсолтод дараах зүйл багтана:

- (1) үйл ажиллагааг эхлэх хуваарьт хугацаанаас хойш 15 минутаас дээш хугацаагаар үйл ажиллагааг эхлүүлэх боломжгүй болох;
- (2) НХҮ-ний хэвийн ажиллагаанд 10 минутаас дээш хугацаагаар гэнэтийн саатал гарах;
- (3) үйл ажиллагааг дуусгах хуваарьт хугацаанаас 30 минут, түүнээс дээш хугацааны өмнө үйл ажиллагааг зогсоох.

172.123. Аюулгүй байдлын удирдлага

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн шаардлагын биелэлтийг бататгах, түүнд хяналт тавих зорилгоор аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.

172.125. НХҮ-ний байгууллагын Ерөнхий заавар

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журамд дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрэм болон бусад холбогдох Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
 - (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг дагаж мөрдөх;
- (1A) 172.123-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) НХҮБ-ын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэр;
- (3) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагыг:
 - (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын болон энэ зүйлийн (a)(5)(i)-д заасан байрлал бүрийг хамарсан үүрэг хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) нэгээс дээш НХҮ-ний нэгжээс НХҮ үзүүлж байгаа тохиолдолд, дараах мэдээллийг заасан хүснэгт:
 - (i) НХҮ-ний нэгжийн байрлал;
 - (ii) үйлчилгээ үзүүлж байгаа аэродром, эсхүл агаарын зай;
 - (iii) үзүүлэх үйлчилгээ.
- (6) НХҮ-ний нэгж тус бүрд ажиллах тухайн хүсэлт гаргагчийн ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) одоогийн үйл ажиллагааны горим, ажилтны чадвар, бэлтгэл нь 172.51-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон мэдээлэл;
- (8) НХҮ-ний ажилтны сургалт болон үнэлгээ, НХҮ-ний сургалтын ажилтны сургалтын ажилтны мэргэшлийн талаар 172.53-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (10) 172.57 (b)(5)(i) ба 172.57(c)(2)(i)-ийн шаардлагыг хануулах зорилгоор ашиглах дэлгэцийн системийн тодорхойлолт;
- (11) үйлчилгээний цаг, НХҮ-г тогтоох болон аливаа шилжилтийн зохицуулалтын талаар 172.59 -д шаардсан мэдээлэл;
- (12) 172.61-д шаардсан ээлжийн зохицуулалтын талаарх журам;

- (13) баримт бичгийн хяналтын талаар 172.63-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (14) 172.65 -д шаардсан нөөц төлөвлөгөө;
- (15) зохицуулалтын шаардлагын талаар 172.67-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (16) байгууламжийн статусыг мэдэгдэх талаар 172.69-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (17) ерөнхий мэдээллийн шаардлагын талаар 172.71-д шаардсан систем болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (18) цаг уурын мэдээ болон мэдээлэх талаар 172.73-д шаардсан систем болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (19) бүсийн удирдлагын болон ойртолтын удирдлагын үйлчилгээний талаар 172.75-д шаардсан систем болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (20) аэродромын удирдлагын үйлчилгээний хангалтын талаар 172.77-д шаардсан систем болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (21) хяналттай нислэг болон идэвхитэй тусгай зориулалтын агаарын зайгаас зай барих талаар 172.79-д шаардсан систем болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (22) удирдлагын хариуцлагын талаар 172.81-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (23) хөдөлгөөний эрэмбэ, давуу эрх олгох талаар 172.83-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (24) нислэгийн хөдөлгөөний урсгалын талаар 172.85-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (25) НХУ-ын зөвшөөрлийн талаар 172.87-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (26) аяллын нислэгийн түвшинг хувиарлах талаар 172.89-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (27) НХУ-ын зөвшөөрлөөс хазайх талаар 172.91-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (28) НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-ний хангалтын талаар 172.93-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (29) аэродромын НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-ний хангалтын талаар 172.95-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (30) анхааруулах үйлчилгээний хангалтын талаар 172.97-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (31) нислэгийн төлөвлөгөө хүлээн авах, дамжуулах талаар 172.99-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (32) цаг, хугацааны талаар 172.101-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (33) 172.103-д шаардсан нислэгийн өндрийн тохируулгын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (34) 172.105-д шаардсан радио холбооны журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (35) радарын үйлчилгээний хангалтын талаар 172.107-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;

- (36) агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон тогтмол бус үйл ажиллагааны талаар 172.109-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (37) ноцтой зөрчил, эсхүл ослын дараах журмын талаар 172.111-д шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (38) зөрчлийн талаар 172.113-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (39) 172.115-д заасан баримтжуулалт, бичлэгийн журам;
 - (40) 172.117-д заасан нислэгийн хөдөлгөөн, ээлжийн бүртгэл, ажлын байрны бүртгэлийн журам.
 - (41) аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар 172.119-д шаардсан хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (42) 172.121-д заасан үйл ажиллагааны саатлын үеийн журам;
 - (43) [нөөц];
 - (44) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

172.151. Байнгын хэрэгжилт

НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) зөвхөн тодорхой байрлалд хамаарах зааврыг үндсэн байрлал болон холбогдох нэгжид хадгалсан байх шаардлагатай байхаас гадна, Ерөнхий зааварт заасан НХҮ-ний нэгж тус бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгална;
- (2) Ерөнхий зааварт заасан бүх журам болон стандартыг дагаж мөрдөнө;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгана;
- (4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлагыг дагаж мөрдөх ба стандартыг байнга хангана;
- (5) САА 24172/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг Даргад нэн даруй мэдэгдэх.

172.151А. Шилжилтийн зохицуулалт

[Хүчингүй]

172.153. Үйл ажиллагааны журам

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн ажилтан мөрдөх, үйл ажиллагааны заавар, эсхүл Ерөнхий зааварт заасан үйлчилгээний зааврын тогтолцоогоор хангана.
- (b) Нэг, эсхүл түүнээс дээш байрлалаас, НХҮ-ний нэгээс дээш төрлийн үйлчилгээ эрхлэх эзэмшигч нь тухайн салбар, нэгж бүрийн онцлогийг харгалзан үйл ажиллагааны журамдаа нэмэлт тодотгол, зааврыг хавсаргаж болно.

172.155. Туршилтын зөвшөөрөл

